

**МОНГОЛ УЛС, ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНД
БАЙГУУЛАХ “ЗҮРХ СУДАСНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ БАЙГУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙН
ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦӨХ ТАЛААРХ ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 09 дүгээр
сарын 29-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдөр Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаараа дээрх хэлэлцээрийн төслийг зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Хэлэлцээрийн төсөлд “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны 34.9 сая ам.долларын зээл болон Люксембургийн Их Гүнт Улсаас олгох 22.5 сая евро /26.4 сая ам.доллар/-ийн буцалтгүй тусламжийн хамтарсан санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Европын сэргээн босголт, хөгжлийн банктай байгуулах зээлийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу заавал соёрхон батлах Олон улсын гэрээ бөгөөд тус зээл нь баталгаат овернайт санхүүжилтийн хүү /SOFR/ дээр 1.6 хувийн нэмэгдэл хүүтэй, 18 жилийн хугацаанд эргэн төлөгдөх, үүнээс 4 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй байна.

Зүрх судасны үндэсний төв байгуулах төслийн хүрээнд 120 ортой тусгай зориулалтын зүрх судасны эмнэлгийн барилгыг шинээр барьж, тоног төхөөрөмжөөр бүрэн ханган ашиглалтад оруулах бөгөөд төсөл хэрэгжсэнээр зүрх судасны төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг 2 дахин нэмэгдүүлж, жил бүр өсөн нэмэгдэж байгаа зүрх судасны өвчлөл, нас баралтын хэмжээг бууруулах өндөр ач холбогдолтой гэж тооцоолжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээрийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд Монголын талаас санхүүжилт байгаа эсэх талаар, мөн барилга байгууламж болон тоног төхөөрөмжид тус бүр хэдэн сая евро зарцуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн эмч нарын хүний нөөцийг дэмжихэд зээл тусламжийн хэдэн хувь нь зарцуулагдах, түргэн тусламжийн нисдэг тэрэгний үйлчилгээг орон нутагт нэвтрүүлэх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга Зүрх судасны үндэсний төв нь Улсын гуравдугаар төв эмнэлгийн өргөтгөл, эсхүл бие даасан эмнэлгийн статустай байх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа тухай бүр зээлийн хүүгийн хэмжээг тогтоосон банкны шийдвэрийг зээлдэгч заавал биелүүлэхээр заасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга Сангийн яам зээлийн тооцооллыг зөв тооцсон эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат өнөөдрийн байдлаар баталгаат овернайт санхүүжилтийн хувьсах хүү хэд байгаа талаар, төсөл хэдий хугацаанд судлагдаад, хэрэгжүүлэгч ямар нэгж байгуулагдаад явсан талаар, мөн цаашид энэ төслийг дотоодын барилгын

компаниудаар гүйцэтгүүлэх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Эрүүл мэндийн яам зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх ямар бодлого барьж байгаа талаар, мөн эрүүл мэндийн салбарыг либералчлах буюу хувийн эмнэлгүүдийг хэрхэн нэвтрүүлэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээрийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Г.Очирбат нар зээлтэй холбоотой санхүүгийн тооцооллыг дахин нэгтгэж ирүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, П.Батчимэг нар Зүрх судасны үндэсний төвийн барилгыг өөр байршилд барих талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн түргэн тусламжийн нисдэг тэрэгний үйлчилгээг нэвтрүүлэх талаарх саналыг тус тус хэлсэн болно.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төслийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Handwritten signature of R. Seddorj in black ink, written over a red rectangular stamp. The stamp contains the text 'ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА' and the numbers 'TUC3761 9023051390 9087184'.

Р.СЭДДОРЖ